



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

1. ХЭЛЭЛЦСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнгийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд нийт 12676 нэгж талбарын 45,465.3 га газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх хамрагдаж нийт 3,594.1 тэрбум төгрөгөөр үнэлэгдэн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 3591.2 тэрбум төгрөгөөр бүртгэгдсэн байна. Үүнд: төрийн өмчит хуулийн этгээдийн 3932 нэгж талбарын 34,933.6 га газар хамрагдаж, нийт 2,315.8 тэрбум төгрөг, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 8744 нэгж талбарын 10,531.7 га газар хамрагдаж 1,278.26 тэрбум төгрөгөөр тус тус үнэлэгдсэн байна.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн 6012 хуулийн этгээдийн нийт 79,445 ширхэг барилга байгууламж 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн "барилга, байгууламж"-ийн дансанд 14,617.68 тэрбум төгрөгөөр бүртгэгдсэн. Үүнээс төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа 20,211 ширхэг барилга, байгууламж 7,773.1 тэрбум төгрөгөөр үнэлэгдэн санхүүгийн тайланд туссан байна. Харин орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа 59,234 ширхэг барилга, байгууламжийн дахин үнэлгээний дүн нь 5,120.5 тэрбум төгрөг байна.

Дахин үнэлгээгээр барилга, байгууламжийн дүн нийт 4,640.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 3,449.0 тэрбум төгрөгийн нэмэгдэл нь төрийн өмчит хуулийн этгээдийнх (төрийн нууцад хамаарах дүнг хассанаар) бол 1,191.99 тэрбум төгрөг нь орон нутгийн өмчит хуулийн этгээдэд ногдож байна.

3. Гадаад улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа 214 ширхэг барилга, байгууламж хамрагдаж 69.5 сая ам.доллар буюу 137 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байсан бөгөөд дахин үнэлгээнд хамрагдсанаар нийт 133.6 сая ам.доллар буюу 296.0 тэрбум төгрөгөөр санхүүгийн тайланд туссан. Гадаад улс дахь Монгол Улсын 23 дипломат төлөөлөгчийн газрын эзэмшилд байгаа 33 нэгж талбарын 99999.06 м.кв талбай бүхий газар хамрагдаж, нийт 22.5 сая ам.доллар буюу 59.8 тэрбум төгрөгөөр үнэлэгдсэн. Газрын үнэлгээг Гадаад харилцааны сайдын балансад валютын холбогдох ханшаар тооцож, нийт 57.4 тэрбум төгрөгөөр тусгасан байна.

000070

Газрын үнэлгээний дүнг санхүүгийн тайланд тусгахдаа өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн байдлаар шалтгаалан 12 дипломат төлөөлөгчийн газрын газар өмчлөх эрхийн үнэлгээ болох 13,4 сая ам.доллар буюу 33.3 тэрбум төгрөгөөр эргэлтийн бус хөрөнгийн “газар” дансанд, 11 дипломат төлөөлөгчийн газрын газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ болох 9,1 сая ам.доллар буюу 24.0 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн “биет бус хөрөнгө”-газар эзэмших эрх дансанд бүртгэсэн байна.

4. Үнэлгээгээр гарсан зөрчил: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, зөрчлийг арилгах талаар 2017 оны 12 дугаар сард үнэлгээний бэлтгэл ажлын зөвлөмж гаргаж төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагад хүргүүлсэн. Гэвч зарим байгууллага газар эзэмших эрхээ хууль тогтоомжийн дагуу баталгаажуулаагүйн улмаас үнэлгээнд хамрагдах боломжгүй болсон байна. Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, эзэмшил газраа үнэлээгүй, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламж, бусдын газар дээр байрладаг, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн газар дээр төрийн бус хуулийн этгээд, иргэний барилга байгууламжийг зөвшөөрөлгүй барьсан, нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний доорх газрыг баталгаажуулаагүй, аргачлалын дагуу үнэлэх боломжтой барилга байгууламжийг үнэлээгүй, үнэлгээг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд буруу тусгасан зэрэг зөрчлүүд илэрлээ. Мөн дахин үнэлгээний үр дүнд үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжууд бүртгэгдсэн байна. Эдгээр зөрчил дутагдлуудыг арилгуулж, дүнг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгах шаардлагатай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнтэй танилцаад “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг дэмжиж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

